



КРЕДИТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ББСБ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 7 сарын 7-ны өдөр

Дугаар 2021/27

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 7 сарын 7-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн толгой компани болох Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д дор дурдсан нөхцөлөөр зээл олгохыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 500,000,000 (Таван зуун сая) төгрөг;
 - 12 сарын хугацаатай;
 - 20 хувийн хүүтэй;
 - Зээл олголтын шимтгэл 1%;
 - Барьцаа хөрөнгө: Гацуурт ХХК-ийн нэг бүр нь 10,000,000 (арван сая) төгрөгийн үнэлгээтэй, 60 ширхэг, Хаалттай бонд;
2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д зээл олгох болсонтой холбогдуулан гэрээ байгуулах, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтаар гаргасан, хэлцлийг батлах санал хураалтад сонирхлын зөрчилтэй этгээдүүд оролцолгүй түдгэлзсэн болохыг дурьдсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ